

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХОРООНЫ  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 12 сарын 28 өдөр

Зуунмод хот

ДД	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжилт
<b>Нэг. Санхүү төсөв, эд хөрөнгийн ашиглалтын талаар</b>			
1	Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг томилогдсон комиссоор хийлгэж данс бүртгэлтэй тулгалт хийх	Хагас, бүтэн жилээр	<p>Хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын комисс томилох тухай А/11 дугаар тушаалаар тооллогын комиссийн бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг 2022 оны 05 дугаар сарын 17-31 өдрүүдэд хийж гүйцэтгэв. Тооллогоор 1451.4 мянган төгрөгийн бичиг хэрэг, 5292.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 14408.4 мянган төгрөгийн үнэт цаас, 432353.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг нүд үзэн тоолсон. Жилийн эцсийн тооллогыг Хэлтсийн даргын 12 сарын 19-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 19-28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Уг тооллогоор 1615,9 мянган төгрөгийн бичиг хэрэг, 8077,7 мянган төгрөгийн үнэт цаас, 24028,7 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 1242102,1 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө тооллоо. Тооллогын явцад дутагдсан үрэгдсэн хөрөнгө гараагүй.</p> <p>Хэрэгжилт 100%</p>

2	Эд хөрөнгө хариуцагч бүрд эд хөрөнгийн карт хөтлүүлж төрийн өмчийн ашиглалт хамгаалалтад хяналт тавих	Жилдээ	<p>Хэлтсийн үндсэн хөрөнгө бараа материалыг эд хөрөнгө хариуцагч бүрийг байлцуулан тоолж тулгалт хийн эд хөрөнгийн картжуулаад байна. Хагас жилийн байдлаар хэлтсийн 22 албан хаагчдад картаар 561 эд хөрөнгө бараа материал хариуцуулан ашиглалтын байдалд нь тогтмол хяналтыг тавин ажил байна. Эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд ажиллахгүй байсан IR3245 маркийн каноны хорыг сольж засварлаж хэлтсийн хэмжээнд хэрэглэж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
3	Ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалт гаргаж өмч хамгаалах зөвлөлд шилжүүлэх	Хагас бүтэн жилээр	<p>2021 оны жилийн эцийн тооллогоор 15 нэр төрлийн 18 ширхэг 8903550,44 мөнгөний үнэ бүхий эд хөрөнгийн актлах саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, ТӨБЗГазрын 6 сарын 7-ны өдрийн А-1/1174 албан тоотыг үндэслэн акталсан болно. 2022 оны хагас жилийн тооллогоор 10 нэр төрлийн 28 ширхэг 69995650 төгрөгийн хөрөнгө актлах саналыг 9 сард УБЕГазарт хүргүүлсэн болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт хийх	Сар бүр	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сар бүрийн 8-ны өдрийн дотор мэдээллийн самбарт байрлуулсан мээдээлэл, цахим сангийн мэдээлэлд хяналт хийж хэвшсэн. Хуулийн хугацаа хэтрүүлж мэдээллээ нийтэд мэдээлээгүй зөрчил дутагдал илрээгүй болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
5	Аудитын албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавих	Сар бүр	<p>Тус хэлтэс нь 2021 оны аудитын зөвлөмжийн дагуу анхан шатны бүртгэлийн маягтыг зааврын дагуу хөтлөн, худалдан авалт хийх бүрт И-баримтыг бүрдүүлэн ажиллаж байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг сар бүр илтгэх хуудсаар тайлагнан хагас жилийн хэрэгжилтийг төв аймгийн Төрийн аудитын газарт алтан бичгээр хүргүүлж, аудитын</p>

			програмд шивж оруулсан болно. Хэрэгжилт 100%
<b>Хоёр.Бүртгэлийн ажлын чиглэлээр</b>			
6	Байгууллагын албан хаагчдын цаг ашиглалт, дотоод журмын хэрэгжилтэд хяналт хийх	Улирал бүрд	<p>Хагас жилийн байдлаар цагийн бүртгэлд түүвэрчилсэн байдлаар 1 сарын 19; 2 сарын 11; 3 сарын 07; 4 сарын 25; 5 сарын 3, 6 сарын 02, 10 сарын 12, 11 сарын 14, 12 сарын 1-ний өдрүүдэд үргэлжлэх, орой, өдрийн аль нэг цагт нь хяналт тавьсан байна. Нийт албан хаагчдын ажилдаа ирсэн гарсан бүртгэлийг хянахад ажлын цагаас хоцорсон, ажлын цаг дуусахаас өмнө гарсан албан хаагч байхгүй байна. Иймд хэлтсийн албан хаагчидын цаг ашиглалтын байдалд “маш сайн” гэсэн үнэлгээг өгч байна.</p> <p>Хэрэгжилт 100 %</p>
7	Байгууллагын архивын үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд хяналт хийх	1, 4-р улиралд	<p>Хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Байгууллагын архивын баримтад тооллого явуулах, ажлын хэсэг байгуулах тухай А\08 дугаар тушаалын дагуу 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллав. Тооллогоор байгууллагын архивын баримтын бодит тоог тогтоож тоо бүртгэлийн баримт бичигт тусгагдсан баримтын тоотой тохирч байгаад хяналт тавьж ажиллав.</p> <p>Хэрэгжилт 100%</p>